



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 4405

Улаанбаатар хот

«Зүү эмчилгээний их эмч, уламжлалт засалчийн албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загвар батлах тухай»

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зүү эмчилгээний их эмчийн албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг нэгдүгээр, уламжлалт засалчийн албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хавсралтын дагуу зүү эмчилгээний их эмч, уламжлалт засалчийн ажлын байрны тодорхойлолтыг баталж, хэрэгжүүлж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтийг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтшинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.





Эрүүл мэндийн сайдын  
2021 оны ... сарын ...-ны өдрийн  
105 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## ЗҮҮ ЭМЧИЛГЭЭНИЙ ИХ ЭМЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар....

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Монгол Улсын стандарт: Монголын уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5700 : 2020

Дагаж мөрдөх огноо: 2021.07 сар

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2021.06 сар

Байгууллагын нэр:

Монголын уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг

Албан тушаалын нэр:

Зүү эмчилгээний их эмч

Ажлын цаг:

Ажлын 8 цаг

Хөдөлмөрийн нэхцэл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Засгийн газрын тогтоолд зааснаар

Ажлын байрны албан ёсны байршил:

Онцгой нэхцэл:

Шаардахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

Байгууллагын тасаг, нэгжийн чиг үүргийн хүрээнд зүү эмчилгээ, уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээг батлагдсан стандарт, удирдамжийн дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх

**Албан тушаалын зорилт:**

- Зүү эмчилгээ, уламжлалт анагаах ухааны тусlamж үйлчилгээг үзүүлэх;
- Уламжлалт анагаах ухааны эм барих;
- Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг үзүүлэх;
- Яаралтай тусlamж үйлчилгээг үзүүлэх;
- Сургалтад хамрагдах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, оролцох;
- Бусад.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Үйлчлүүлэгчийг тасаг, кабинетэд хүлээн авах, асуумж авах, үзлэг хийх, үйлчлүүлэгчийн эмнэлгийн карт, эрүүл мэндийн дэвтэр, өвчиний түүх зэрэг холбогдох анхан шатны маягт, баримт бичгүүдийг стандартын дагуу хөтлөх;</p> <p>2. Зүү эмчилгээний онол, оношилгооны арга зүйн дагуу зонхилон тохиолдох өвчнийг орчин үеийн анагаахын аргуудтай хослуулан оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар, стандарт, удирдамжийн дагуу оношлох, эмчлэх;</p> <p>3. Зүү эмчилгээний аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, амьдралын чанарыг сайжруулах, хөнгөвчлөх эмчилгээ хийх;</p> <p>4. Дотрын өвчин, мэдрэлийн өвчин, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гадар өвчин, хүүхдийн зарим эмгэгүүдийг зүү төөнө заслаар эмчлэх;</p> <p>5. Их биеийн зүү эмчилгээ, толгой, чих, бусад бичил зүү эмчилгээ, цахилгаан зүү эмчилгээ хийх;</p> <p>6. Уламжлалт анагаах ухааны бичил ханах засал (зүүний сүвд</p>	<p>Сарын, улирлын төгсгөлд тайлан мэдээ, бичиг баримтын хөтлөлт хийгдсэн, үйлчлүүлэгчдийн санал хүсэлт авсан, сэтгэл ханамжийн судалгааг хийгдсэн байна.</p> <p>Оношилгоо эмчилгээний эмнэлзүйн зааврууд, түгээмэл үйлдлийн стандартууд эмчийн хавтсанд хийгдсэн, бүрэн танилцсан, тусlamж үйлчилгээнд саадгүй ашиглах чадвартай болсон байна.</p> <p>Зүү эмчилгээний аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хөнгөвчлөх эмчилгээний заавар, стандартууд хаваст хийгдсэн, бүрэн танилцсан, тусlamж үйлчилгээнд саадгүй ашиглах чадвартай, гүйцэтгэхэд шаардлагатай гардан үйлдлийн чадвартай болсон байна.</p> <p>Стандарт үйл ажиллагааны зааврын дагуу эмчилгээ хийх чадвартай байна.</p> <p>Стандарт үйл ажиллагааны зааврын дагуу эмчилгээ хийх чадвартай байна</p> <p>Тогтмол хуваарийн дагуу эмч нарын тойрон үзлэг</p>	Г Г Г Г Г Г

	<p>хатгалт хийж цус гаргах, хануурын судсыг ханах), шивүүр эмчилгээ хийх, шууд болон дам төөнө, цахилгаан төөнө хийх, туйна бария засал, хусуур эмчилгээ (гуаша) хийх;</p> <p>7. Үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ хийх, эмчилгээний үр дүнг үнэлэх, хянах, шаардлагатай шинжилгээг хийх;</p> <p>8. Жижүүр эмчийн үүргийг хуваарийн дагуу гүйцэтгэх;</p> <p>9. Шаардлагатай нөхцөлд бусад эмчээс зөвлөгөө авах, эмч нарын зөвлөгөөн хийлгэх, хүндрэлээс сэргийлэх;</p> <p>10. Шаардлагатай нөхцөлд үйлчлүүлэгчийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх, хянах;</p> <p>11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгээс шалтгаалсан халдварын дэглэм, зааврыг мөрдөх;</p> <p>12. Сувилагч, уламжлалт засалч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнд эмчилгээ, сувилгааны чиглэлээр зааварчилгаа өгөх, хяналт тавих;</p> <p>13. Үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагчид эрүүл мэндийн байдал, эмчилгээ, үр дүн, эрсдэл, хүндрэлийн талаар энгийн ойлгомжтой хэллэгээр тайлбарлах, зөвлөгөө өгөх;</p> <p>14. Эмнэлгээс гарах үеийн дүгнэлтийг өвчний түүх, үйлчлүүлэгчийн эмнэлгийн картанд бичих.</p>	<p>хийгдэж бүртгэл баримтаар баталгаажсан байна.</p> <p>Тогтмол хуваарийн дагуу эмч нарын тойрон үзлэг хийгдэж, бүртгэл баримтаар баталгаажсан байна.</p> <p>Жижүүр эмчийн хуваарь, тэмдэглэлээр баталгаажсан байна.</p> <p>Тусlamж үйлчилгээний хүрээнд шинжилгээ хийгдсэн, баримт бичиг хөтлөгдсэн байна.</p> <p>Эмчлүүлэгчийн хувийн үзлэгийн картанд эмнэлэгт хэвтсэн тухай эпикриз бичигдсэн байна.</p> <p>Хавтас бүрдүүлэлт хийгдсэн байна. Өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгосон байна.</p> <p>Өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгосон байна.</p> <p>Өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгосон байна.</p> <p>Зохих журмын хүрээнд эмнэлгийн магадлагаа эмчлүүлэгчид олгогдсон байна. Дүн бүртгэл хийгдсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г, Х</p> <p>Г, Х, Т</p> <p>Г, Х</p> <p>Г, Х, Ш</p> <p>Г, Х, Ш</p> <p>Г, Х, Ш</p>
2 дугаар зорилтын хүрээнд	1. Үйлчлүүлэгчид оношийн үндсэн дээр тохирох уламжлалт дан болон олон найрлагат үндсэн эмийн жоруудыг бичиж өгөх, эмийн хэрэглэх заавар, үйлдлийг тайлбарлаж өгөх.	Зүү төөнө заслын оношилгоо, эмчилгээний оношилгоо эмчилгээний эмнэлзүйн зааврууд эмчийн хавтаст хийгдсэн, бүрэн танилцсан, тусlamж үйлчилгээнд саадгүй	Г

		ашиглах чадвартай байна.	
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Үйлчлүүлэгчид эрүүл амьдралын хэв маяг, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;</p> <p>2. Зүү эмчилгээний аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх;</p> <p>3. Нийгмийн эрүүл мэндийн бусад үйл ажиллагаанд оролцох;</p> <p>4. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр тасаг, нэгжийн хүрээнд сургалт зохион байгуулах, оролцох.</p>	<p>Сургалтын төлөвлөгөө хийгдэж, сургалт явагдсан байна.</p> <p>Өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар үйлчлүүлэгчид мэдээлэл өгч, танилцуулсан байна.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцено.</p> <p>Сургалтын төлөвлөгөө хийгдэж, сургалт явагдсан байна.</p>	Г Г Г Г
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Амь тэнссэн болон яаралтай тохиолдолд амилуулах суурь тусlamжийн арга хэмжээ авах;</p> <p>2. Ажлын байранд байгаа эсэхээс үл хамааран харьяалал, товтол харгалзахгүй эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлэх;</p> <p>3. Олон улсын хэл хориот өвчний голомт, гамшгийн үед дайчлагдан ажиллах.</p>	<p>Яаралтай үеийн тусlamж үйлчилгээг стандартын дагуу үзүүлсэн байна. Тэмдэглэл хөтлөгдсөн байна.</p> <p>Яаралтай тусlamжийн сургалт явагдсан байна.</p> <p>Хуульд заагдсан үүргийн дагуу шаардлагатай бол дайчлагдан ажиллана. Тушаал, гүйцэтгэлээр үнэлэгдэнэ.</p>	Г Г Г

5 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөөний дагуу сургалтад хамрагдах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх;	Жилийн төлөвлөгөөнд байна. Үр дүнгээр баталгаажна.	Г, Х, Ш, Т
	2. Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, эрсдлийн менежмент, халдвараас сэргийлэх талаар сургалтад хамрагдаж, өөрийн болон үйлчилүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх, эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх мэдлэг, чадварыг эзэмших;	Эмнэлгийн чанар, эрсдэлийн менежмент, халдвараас сэргийлэх стандарт, удирдамж, бичиг баримт хавтсанд хийгдсэн, бүрэн танилцсан, тусlamж үйлчилгээнд саадгүй ашиглах чадвартай болсон байна.	Г
	3. Бусад их эмч, уламжлалт засалч, сувилагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд дэмжтэг үзүүлэх;	Жилийн төлөвлөгөөнд тусагдсан байна. Үр дүнгээр баталгаажна.	Г, Т, Х
	4. Эрдэм шинжилгээ, судалгааны багт орж ажиллах, онол практикийн хуралд илтгэл тавих;	Эрдэм шинжилгээ, судалгааны тайлангаар баталгаажна.	Г, Т
	5. Оношилгоо, эмчилгээний гарын авлага, аргачлал, мэргэжлийн ном туурвих, орчуулахад оролцох.	Хэвлэн нийтлүүлсэн бүтээлээр баталгаажна.	Г, Т
6 дугаар зорилтын хүрээнд	1. Бусад эрүүл мэндийн байгууллагын эмч нартай харилцан мэдээлэл солилцох, сургалт зохион байгуулах;	Жилийн төлөвлөгөөнд тусагдсан байна.	Г, Т
	2. Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх;	Жилийн төлөвлөгөөнд тусагдсан байна.	Г
	3. Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох;	Тушаал, гүйцэтгэлээр үнэлэгдэнэ.	Г
	4. Хууль эрх зүйн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх.	Ёс зүй, хууль эрх зүйн сургалтад хамрагдсан байна.	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй тэгссэн (магистр болон түүнээс дээш зэрэгтэй бол давуу тал болно)
Мэргэжил	Уламжлалт анагаахын их эмч/Зүү эмчилгээний их эмч
Мэргэшил	- Зүү эмчилгээний чиглэлээр үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдсан буюу мэргэшлийн үнэмлэхтэй байх;


	<ul style="list-style-type: none"> <li>- Төрөлжсэн мэргэшлийн сургалтад хамрагдсан буюу мэргэшлийн үнэмлэхтэй байх;</li> <li>- Ахлах, тэргүүлэх, зөвлөх мэргэжлийн зэрэгтэй байх.</li> </ul>
<b>Туршлага</b>	5 жилийн хугацаатай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй
<b>Үр чадвар</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах;</li> <li>- Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх;</li> <li>- Багаар ажиллах чадвартай;</li> <li>- Яриа, харилцаа, хувийн өндөр соёлтой байх;</li> <li>- Хууль эрх зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх;</li> <li>- Хэрэглээний программ бүрэн ашиглах;</li> <li>- Интернэтийн орчинд, дотоод сүлжээнд чөлөөтэй ажиллах.</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр: Эмнэлгийн дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, тасаг, амбулатори, кабинетын эрхлэгч	
Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:  Сувилагч, туслах сувилагч, уламжлалт засалч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, бусад ажилтан	<p><b>Бусад харилцах субъект</b></p> <p>Байгууллагын дотор талд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эмнэлгийн дарга;</li> <li>- Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга;</li> <li>- Тасгийн эрхлэгч, уламжлалт анааахын эмч нар, уламжлалт засалч, сувилагч, туслах сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, бусад ажилтан;</li> <li>- Бусад тасаг, нэгжийн эмч, эрхлэгч, сувилагч, туслах сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, бусад ажилтан.</li> </ul> <p>Байгууллагын гадна талд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгч, түүний гэр бүл, асран хамгаалагч;</li> <li>- Бусад эрүүл мэндийн байгууллагын зүү эмчилгээний болон уламжлалт анааахын эмч, уламжлалт засалч, сувилагч;</li> <li>- Бусад эрүүл мэндийн байгууллагын төрөлжсэн мэргэшлийн эмч, сувилагч;</li> <li>- Тухайн мэргэжлийн чиглэлээрх мэргэжлийн нийгэмлэг, холбоод;</li> <li>- Төрийн болон төрийн бус бусад байгууллага.</li> </ul>

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<p><b>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</b></p>	<p><b>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</b></p>
<p><u>Албан тушаал:</u> .....</p> <p>.....</p> <p>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)</p>	<p><u>Байгууллагын нэр:</u> .....</p> <p><u>Шийдвэрийн огноо:</u> .....</p> <p><u>Дугаар:</u> .....</p>
<p>20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	
<p><b>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</b></p>	
<p><u>Байгууллагын нэр:</u> .....</p> <p><u>Шийдвэрийн огноо:</u> .....</p> <p><u>Дугаар:</u> .....</p> <p>(тамга/тэмдэг)</p> <p>.....</p> <p>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)</p> <p>20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
2021 ОНЫ 06. САРЫН 23-НЫ ӨДРИЙН  
*Чиг*-дугаар тушаалын 2 дугаар хавсралт

## УЛАМЖЛАЛТ ЗАСАЛЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар.....

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
 шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Монгол Улсын стандарт: Монголын уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа  
MNS 5700 : 2020

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Монголын уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг

Албан тушаалын нэр:

Уламжлалт засалч

Ажлын цаг:

Ажлын 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Засгийн газрын тогтоолд зааснаар

Ажлын байрны албан ёсны байршил:

Онцгой нөхцөл:

Шаардахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгууллага, тасаг, нэгжийн чиг үүргийн хүрээнд уламжлалт анагаахын тусlamж, үйлчилгээ, гэмтэл бэртлийн үед сэргээн засах, уламжлалт бария заслын тусlamж үйлчилгээ үзүүлэх

Албан тушаалын зорилт:

- Уламжлалт анагаахын тусlamж үйлчилгээг үзүүлэх;
- Гэмтэл бэртлийн үед сэргээн засах, уламжлалт бария заслын тусlamж үйлчилгээг үзүүлэх;
- Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлэх;
- Бусад.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Уламжлалт анагаах ухааны түгээмэл үйлдлийн удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу ханах заслын бэлтгэл, төөнөх заслыг хийх;</p> <p>2. Соруул тавих, самнуур, шивүүр хийх;</p> <p>3. Усан эмчилгээ, шавар, рашаанд өвчтнийг бэлтгэж, оруулах;</p> <p>4. Туулгах, бөөлжүүлэх засалд өвчтөнийг бэлтгэж, заслыг хийх;</p> <p>5. Иог, бясалгалын эмчилгээг хийх;</p> <p>6. Уламжлалт анагаах ухааны идээ ундаа, явдал мөрийн эмчилгээг хийх;</p> <p>7. Үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагчид эрүүл мэндийн байдал, эмчилгээ, үр дүн, эрсдэл, хүндрэлийн талаар энгийн ойлгомжтой хэллэгээр тайлбарлах, зөвлөгөө өгөх;</p> <p>8. Үйлчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг хянах, эмчлэгч эмчид мэдээлэх.</p>	<p>Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар, түгээмэл үйлдлийн стандартууд хавтаст хийгдсэн, бүрэн танилцсан, тусlamж үйлчилгээнд саадгүй ашиглах чадвартай байна.</p> <p>Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө өгсөн, сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна.</p> <p>Tuslamж, үйлчилгээний хүрээнд шинжилгээ, эмчилгээ хийгдсэн, баримт бичиг хөтлөгдсөн байна.</p>	Г Г Г,Х
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Ахуйн болон спортын гэмтэл бэртлийг оношилж, сэргээн засах болон уламжлалт жudo бария заслын аргаар эмчлэх;</p> <p>2. Уламжлалт анагаах ухааны бария засал (бүх биеийн, хэсэгчилсэн, зөвлөн тосон, сүүн, шөлөн, шимжүүлэх бария) хийх;</p> <p>3. Зөвлөн эдийн бэртэл, гэмтлийг оношилж сэргээн засах, жudo бария заслын эмчилгээ хийх;</p> <p>4. Гипс болон уян боолт тавих;</p>	<p>Tuslamж үйлчилгээний хүрээнд шинжилгээ хийгдсэн, баримт бичиг хөтлөгдсөн байна. Гардан үйлдлийн чадвартай байна.</p> <p>Гардан үйлдлийн чадвартай байна.</p> <p>Tuslamж үйлчилгээний хүрээнд шинжилгээ хийгдсэн, баримт бичиг хөтлөгдсөн байна. Гардан үйлдлийн чадвартай байна.</p> <p>Гардан үйлдлийн чадвартай байна.</p>	Г Г Г

	<p>5. Гэмтлийн дараах сэргээн засах эмчилгээг хийх;</p> <p>6. Физик эмчилгээний аппарат, тоног төхөөрөмжийг ажиллуулах;</p> <p>7. Хөдөлгөөнт дасгал, эмчилгээ хийх;</p> <p>8. Тамирчдыг бэртэл, гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.</p>	<p>Чадвартай байна.</p> <p>Гардан үйлдлийн чадвартай байна.</p> <p>Тогтмол хуваарийн дагуу хийгдэж, бүртгэл баримтаар баталгаажсан байна.</p> <p>Гардан үйлдлийн чадвартай байна.</p> <p>Тогтмол хуваарийн дагуу хийгдэж, бүртгэл баримтаар баталгаажсан байна.</p>	Г Г Г Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Үйлчлүүлэгчид эрүүл аж төрөх ёс, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр зөвлөгөө өгөх;</p> <p>2. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр тасаг, нэгжийн хүрээнд сургалт зохион байгуулах, оролцох;</p> <p>3. Нийгмийн эрүүл мэндийн бусад үйл ажиллагаанд оролцох.</p>	<p>Жилийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна. Үр дүнгээр баталгаажна</p> <p>Сургалтын төлөвлөгөө хийгдэж, сургалт явагдсан байна.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцно.</p>	Г Г Г
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Сургалтад хамрагдах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх;</p> <p>2. Эрдэм шинжилгээ, судалгааны багт орж ажиллах, онол практикийн хуралд илтгэл тавих;</p> <p>3. Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх;</p>	<p>Жилийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.</p> <p>Эрдэм шинжилгээ, судалгааны тайлангаар баталгаажна.</p> <p>Жилийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.</p>	Г Г Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн
Мэргэжил	Уламжлалт засалч
Мэргэшил	-
Туршлага	Мэргэжлээрээ ажиллах чадвартай байх.
Үр чадвар	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахин ажиллах;</li> <li>- Авлигын эсрэг хуулийн хүрээнд ажиллах, авлигаас ангид байх;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Багаар ажиллах чадвартай;</li> <li>- Яриа, харилцаа, хувийн өндөр соёлтой байх;</li> <li>- Хууль эрх зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- Англи хэлний анхан шатны мэдлэгтэй байх;</li> <li>- Хэрэглээний программ бүрэн ашиглах;</li> <li>- Интернэтийн орчинд, дотоод сүлжээнд чөлөөтэй ажиллах.</li> </ul>
--	---

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:  
Эмнэлгийн дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, тасаг, амбулатори, кабинетийн эрхлэгч

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	<p>Сувилагч, туслах сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, бусад ажилтан</p> <p>Бусад харилцах субъект</p> <p>Байгууллагын дотор талд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эмнэлгийн дарга;</li> <li>- Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга;</li> <li>- Тасгийн эрхлэгч, сэргээн засахын эмч, бусад мэргэжилтэн, уламжлалт анааахын эмч, зүү төөнө заслын эмч, сувилагч, туслах сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, бусад ажилтан;</li> <li>- Бусад тасаг, нэгжийн эрхлэгч, эмч, сувилагч, туслах сувилагч, эмнэлгийн бусад тусгай мэргэжилтэн, бусад ажилтан;</li> <li>- Спортын клуб, баг, дэвжээний удирдлага, дасгалжуулагч, менежер, бусад ажилтан.</li> </ul> <p>Байгууллагын гадна талд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үйлчлүүлэгч, түүний гэр бүл, асран хамгаалагч;</li> <li>- Тамирчид, түүний гэр бүл, асран хамгаалагч;</li> <li>- Бусад эрүүл мэндийн байгууллагын уламжлалт анааахын эмч, сувилагч;</li> <li>- Уламжлалт анааах ухаан болон жудо бария засал, спортын чиглэлийн мэргэжлийн холбоо, их сургуулиуд;</li> <li>- Сувилал;</li> <li>- Төрийн болон төрийн бус бусад байгууллага.</li> </ul>
---	---

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<u>Албан тушаал:</u> ..... ..... (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ..... <u>Шийдвэрийн огноо:</u> ..... <u>Дугаар:</u> ..... .....
<b>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</b>  <u>Байгууллагын нэр:</u> ..... <u>Шийдвэрийн огноо:</u> .....  <u>Дугаар:</u> .....  (тамга/тэмдэг)  ..... (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр	